



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА
ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нийцлийн аудитын тайлан

**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын бүрдүүлэлт,
зарцуулалт, үр дүн**



**ХЭДС-гаас эргэн төлөгдөх нөхцөлтөй олгосон зээлийн
эргэн төлөлт болон тус сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж
буй төсөл, хөтөлбөр, дэмжлэгийн үр өгөөж, үр дүн
хангалтгүй байна.**

2016 он

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн: Говьсүмбэр аймгийн Аудитын газар Аймгийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ш.Ичинхорлоо Аудитын менежер Б.Сарантуяа Ахлах аудитор Ц.Батсайхан Аудитор Л.Отгонпүрэв 2016 оны 05 дугаар сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7054-3151 дугаарын утас, 7054-3179 дугаарын факсаар харилцана уу. ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 давхар, 217 тоот	Товчилсон үгийн тайлбар4 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....5 Бүлэг 1. ХЭДС-ийн орлогыг төлөвлөгөөг жил бүр дутуу биелүүлж, орлогыг ХЭДТөв сандаа төвлөрүүлж ажилласан байна. 1.1 ХЭДС-ийн орологын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүй байна. 1.2 ХЭДС-ийн хуваарийн дагуу төлөх зээлийн эргэн төлөлтийг 33 иргэн 11,243.1 мянган төгрөгөөр дутуу төлсөн байна. 1.3 ХЭДС-ийн журмын дагуу орон нутгийн төсвөөс ХЭДС-ийн дэд санд хөрөнгө хуваарилаагүй байна. 1.4 ХЭДС-д төвлөрүүлэх Хөдөлмөрийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг бодит тооцоо, судалгаанд үндэслэлгүйгээр төлөвлөж, баталж ирсэн байна 1.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажилуулаагүй төлбөрийг төлөх байгууллагын нэгдсэн судалгаагүй байгаа нь уг төлбөрийг жил бүр дутуу төвлөрүүлэхэд нөлөөлсөн байна. Бүлэг 2. ХЭДС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүйгээс 26,417.7 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, олгосон зээлийн эргэн төлөлтийг дутуу төлсөн байна. 2.1. ХЭДС-аас хөтөлбөрийн зорилгыг хангаагүй иргэнд зээл олгосон байна. 2.2. ХЭДС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөрийн санхүүжилтээс нийт 26,417.7 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, уг сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна. 2.3. ХЭДС-ийн хөрөнгийн хөрөнгөөр бэлтгэгдсэн 14,149.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна. Бүлэг 3. ХЭДС-ийн хөрөнгийн зарцуулалтыг олон нийтэд ил тод мэдээлж байгаа боловч, хэрэгжилтэнд нь тавих хяналт хангалтгүй байна . 3.1.ХЭДС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна. 3.2.ХЭДС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар олон нийтэд ил тод мэдээлж байна. 3.3.ХЭДС-ийн үйл ажиллагаанд хийсэн хөндлөнгийн хяналт шалгалтын байгууллагаас өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.
--	--

Товчилсон үгийн тайлбар

ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ххэнхбидх	Хувиараа хөдөлмөр эрхлэх нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр
хэдтх	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
ОУБ	Олон улсын байгууллага
НББ	Нягтлан бодох бүртгэл
ХЭҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл
ХЭСЗ	Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэхэд аудит хийж, аудитаар илэрсэн эрсдэлийг үнэлэн холбогдох дүгнэлт зөвлөмж боловсруулан дүнг аймгийн ИТХ, бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилгуулах, давтан гаргуулахгүй байхад аудитын зорилго чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийнэ. Үүнд:

- ХЭДС-ийн орлогын бүрдүүлэлт, хуваарилалт
- ХЭДС-ийн хөрөнгийн зарцуулалт, олгосон зээлийн ашиглалт, үр дүн
- ХЭДС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, олон нийтэд ил тод мэдээлсэн эсэх.

Аудитын хамрах хүрээ

Аудитад Хөдөлмөрийн хэлтэс, аймаг, сумдын ЗДТГ, Багийн Засаг дарга нар, ХЭДС-гаас жижиг зээл олгох үйл ажиллагааг гүйцэтгэсэн банк, Санхүү төрийн сангийн хэлтэс, ХЭДС-ийн 2014-2015 он, 2016 оны 01-р улирлын санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан холбогдох баримт материалыг хамруулна.

Үндсэн мэдээлэл:

Хөдөлмөрийн яамнаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр 2015 онд аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаанд нийт 579.268.0 мянга, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрт 8,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр тус тус төлөвлөсөн байна.

Тайланд онд төвийн санхүүжилт 540,000.0 мянга, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрт 3,228.6 мянга, өмнөх оны төслийн санхүүжилт 1,215.0 мянга, зээлийн эргэн төлөлт 262,016.5 мянга, нийт 806,460.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлэн ажилласан байна. ХЭДС-гаас хэрэгжүүлж буй 7 хөтөлбөр төслийг 5 мэргэжилтэн хариуцан ажиллаж байна.

Аймгийн ХЭДС-гаас 2015 онд “Ажилтай орлоготой Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн 2015 оны 07 дугаар тогтоолоор баталсан орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн 5 хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилласан байна.

Эдгээр хөтөлбөрүүдийн хүрээнд 2015 онд 462 ААНБ-уудаас ажлын байрны захиалга ирүүлж, 310 шинэ ажлын байр, 354 түр ажлын байр бий болсон байна. Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй 200 иргэн хөтөлбөр төсөлд хамрагдаж өрхийн орлогоо нэмэгдүүлсэн бол давхардсан тоогоор 1126 иргэнийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн богино хугацаанд ур чадвар олгох, аж ахуй эрхлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтуудад хамруулсан байна.

Бүлэг 1


ХЭДС-ийн орлогыг төлөвлөгөөг жил бүр дутуу биелүүлж, орлогыг ХЭДТөв сандаа төвлөрүүлж ажилласан байна.

1.1. ХЭДС-ийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүй байна.

ХЭДС-ийн орлогыг 2014 онд 10.000.0 мянга, 2015 онд 8,000.0 мянга, 2016 онд 8,000.0 мянган төгрөгөөр тус тус төлөвлөж, баталсан боловч орлогын төлөвлөгөөг жил бүр 4,773.4-7,235.2 мянган төгрөгөөр дутуу биелүүлсэн байна. Тухайлбал: 2014 онд 2,764.8 мянга, 2015 онд 3,228.6 мянга, 2016 оны 01-р улиралд 1,728.0 мянга нийт 7,721.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэн төвлөрүүлж, 2014 онд 2,764.8 мянга, 2016 онд 1,728.0 мянга, нийт 4,492.8 мянган төгрөгийн орлогыг ХЭДТөв санд, 2015 онд 3,228.6 мянган төгрөгийг Сангийн яаманд тус тус төвлөрүүлж, ХЭДС-ийн санхүүгийн тайланд авлага үүсгэн бүртгэж, тайлагнаж ирсэн байна.

ХЭДС-ийн 2014-2015, 2016 оны 1 дүгээр улирлын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн шинжилгээг графикаар харуулбал:

Орлогын төлөвлөгөө



Дээрх графикаас харахад: 2014 онд 7,235.2 мянган төгрөгөөр буюу 72.4 хувиар, 2015 онд 4,771.4 мянган төгрөг буюу 59.7 хувиар, 2016 оны улирлын байдлаар 272.0 мянган төгрөгөөр буюу 13.6 хувиар тус тус сангийн орлогыг дутуу биелүүлсэн байна.

Энэ нь Хөдөлмөрийн хэлтсийн холбогдох ажил хариуцсан мэргэжилтэн нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүйн төлбөрийг төлөөгүй ААНБ-уудад хяналт шалгалт хийж, төлбөрийн акт тавих эрхгүй байгаагаас шалтгаалсан байна..

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2-т “ААНБ энэ хуулийн 111.1-д заасан хэмжээнд тахир дутуу буюу одой хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр төлбөр төлнө” Хөдөлмөр эрхлэлтийг

дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.7-д “ХЭДС-ийн орлого нь Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрөөс бүрдэнэ”, МУ-ын ЗГ-ын 2009 оны 26-р тогтоолд “ ААНБ-ууд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 30 хувиар тооцож сар бүр төлж байх”, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т “Хуулийн дагуу улс орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэснийг тус тус зөрчсөн байна.


Иймд ХЭДС-ийн батлагдсан орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

1.2. ХЭДС-ийн хуваарийн дагуу төлөх зээлийн эргэн төлөлтийг 33 иргэн 11,243.1 мянган төгрөгөөр дутуу төлсөн байна.

ХЭДС-аас 2014-2015 онд Малжуулах зээл, 2015 онд Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих зээлийг тус тус 2 жилийн хугацаатай, 50 хувийн хөнгөлөлттэй олгосон байна. Үүнд:

2014 онд 12 малчин иргэнд малжуулах зээл 60,000.0 мянга, 2015 онд 12 малчин иргэнд малжуулах зээл 55,855.0 мянга, 1 малчны бүлэгт багаж, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх зээл 5,000.0 мянга, нийт 120,855.0 мянган төгрөгийн зээл олгосон байна.

2014-2015 онд олгосон зээлийн бүтцийг диграмааар харуулбал:



Диаграмаар харахад 2014 онд олгосон нийт зээлийн 15 хувийг малжуулах зээл, 81 хувийг жижиг бизнес эрхлэх иргэн нөхөрлөл, хоршоог дэмжих зээл, 4 хувийг ХБИ-ийг дэмжих санхүүгийн дэмжлэг эзлэж байгаа бол 2015 онд зээлийн нийт зээлийн 19 хувийг малжуулах зээл, 33 жижиг бизнес эрхлэх иргэн нөхөрлөл, хоршоог дэмжих зээл, 10 хувийг ХБИ-ийг дэмжих санхүүгийн дэмжлэг, 36 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэх нөхөрлөл хоршоог дэмжих зээл, 2 хувийг малчдын бүлэгт багаж, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх зээл тус тус эзэлж байна.

Дээрх малжуулах зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу 2015 онд 12 иргэнээс зээлийн эргэн төлөлт 9,600.0 мянга, 2016 оны 05-р сарын 01-нд 22 иргэнээс 19,208.1 мянга, нийт 28,808.1 мянган төгрөгийн зээл эргэн төлөгдөхөөс 2015 онд 9,600.0 мянга, 2016 оны 05-р сарын 01-нд 13,067.5 мянга, нийт 22,667.5 мянган төгрөгийн зээл төлөгдөж, 13 иргэн 7,388.1 мянган төгрөгийн зээлийг дутуу төлөгдсөн байна.

Мөн 2015 онд Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих зорилгоор 104,957.5 мянган төгрөгийн зээлийг 70 иргэнд олгосон ба зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу 2015 онд 23 иргэн 3,468.5 мянга, 2016 оны 05-р сарын 01-нд 70 иргэн 11,049.5 мянга, нийт 14,518.0 мянган төгрөгийн зээлийг эргэн төлөхөөр гэрээ байгуулсан боловч 2015 онд 2,416.5 мянга, 2016 оны 05-р сарын 01-нд 8,604.5 мянга, нийт 11,021.0 мянган төгрөгийн зээл эргэн төлөгдсөн ба 6 иргэн 680.0 мянган төгрөг дутуу, 2016 оны 05-р сарын 01-нд 20 иргэн 3,175.0 мянган төгрөгийн зээлийг тус тус дутуу төлсөн байна.

Эдгээр зөрчил нь эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийг зээлийн барьцаа хөрөнгөгүй олгосон, мөн зээлийн гэрээнд тус сангаас олгосон зээл эргэн төлөлтийн хуваарийн дагуу хугацаандаа төлөгдөөгүй тохиолдолд тооцох хариуцлага, мөн хугацаа хэтэрсэн зээлд хүү алданги, торгууль тооцох, заалт зэргийг оруулж өгөөгүйгээс шалтгаалсан байна.

Иймд зээлийн гэрээнд дээрх хариуцлагын заалтуудыг оруулж, хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт хийгээгүй иргэд, хувиараа аж ахуй эрхлэгч нарт хариуцлага тооцож, зээлийн төлөлтийг хугацаанд нь барагдуулж байх арга хэмжээ авч ажиллах тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

1.3. ХЭДС-ийн журмын дагуу орон нутгийн төсвөөс ХЭДС-ийн дэд санд хөрөнгө хуваарилаагүй байна.


Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолын 2.2-т “Дэд санд аймаг, нийслэл дүүргийн төсвөөс жил бүр олгох хөрөнгийн хэмжээ нь тухайн төсвийн орлогын 0.3 хувиас доошгүй байна” гэж заасны дагуу 2014-2016 онуудад орон нутгийн төсвөөс ХЭДС-ийн дэд санд хуваарилах хөрөнгийг төлөвлөж, батлуулж, хуваарилаагүй байна.

1.4. ХЭДС-д төвлөрүүлэх Хөдөлмөрийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг бодит тооцоо, судалгаанд үндэслэлгүйгээр төлөвлөж, баталж ирсэн байна.

ХЭДС-д төвлөрүүлэх ХБИ-ийг ажиллуулаагүй төлбөрийг аймгийн Хөдөлмөрийн хэлтэс жил бүр холбогдох тооцоонд үндэслэн төлөвлөж, дээд шатны байгууллагад хүргүүлдэг хэдий ч дээд шатны байгууллагаас жил нэмэгдүүлэн баталж ирүүлснээс шалтгаалан тус төлбөрийн орлогын төлөвлөгөө жил бүр тасарсан байна. Тухайлбал:

Хөдөлмөрийн хэлтсээс 2014 онд уг орлогыг төлөвлөөгүй, харин 2015 онд 5,500.0 мянга, 2016 онд 7,000.0 мянган төгрөгөөр тус тус төлөвлөсөн боловч төсвийг батлахдаа уг төлбөрийг 2014 онд 10,000.0 мянга, 2015 онд 2,500.0 мянга, 2016 онд 1,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн 2014 онд 10,000.0, 2015, 2016 онуудад тус бүр 8,000.0 мянган төгрөгөөр баталсан байна.

2014-2016 онуудад ХБИ ажиллуулаагүйн төлбөрөөс бүрдүүлэх орлогыг төлөвлөсөн, баталсан судалгааг графикаар харуулбал:



ХЭДС-нд ХБИ ажиллуулаагүй төлбөрийн орлого 2014 онд 2,764.8 мянга, 2015 онд 3,228.6 мянга, 2016 оны 01-р улиралд 1,728.0 мянга, Малжуулах арга хэмжээнд олгосон зээлийн эргэн төлөлт 2015 онд 9,600.0 мянга, 2016 оны 01-р улиралд 8,00.0 мянга, ХХЭНХБИ-ийг дэмжих зээлийн эргэн төлөлт 2015 онд 2,416.5 мянга, 2016 оны 01-р улиралд 3,779.5 мянга, 2015 онд Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн төслийн санхүүжилт 1,215.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, ХЭДТС-д төвлөрүүлсэн байна.

1.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй төлбөрийг төлөх байгууллагын нэгдсэн судалгаагүй байгаа нь уг төлбөрийг жил бүр дутуу төвлөрүүлэхэд нөлөөлсөн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.7-д “ХЭДС-ийн орлого нь Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр”-өөс бүрдэнэ гэж заасан бөгөөд уг төлбөрийг МУ-ын ЗГ-ын 2009 оны 26-р тогтоолоор ААНБ-ууд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 30 хувиар тооцож сар бүр төлж байхаар баталсан байна.

2014-2016 онуудад аймгийн хэмжээнд ХБИ ажиллуулах байгууллагын судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1 /мян.төг/

Д/д	Огноо	Байгууллагын тоо	Ажилчдын тоо	Ажиллуулах ХБИ тоо	Ажиллуулсан ХБИ тоо	Төлбөр төлөх ХБИ тоо	Нийт төлөх ХБИА төлбөр	Төлсөн төлбөр	Төлөөгүй төлбөр
1	2014 он	16	1,284	46	30	16	11,059.2	2,764.5	8,294.7
2	2015 он	24	1,725	62	25	37	25,574.4	3,228.5	21,654.7
3	2016 оны 01-р улир	23	1,808	64	30	34	5,875.2	1,728.0	4,147.2
Нийт тоо		63	4,817	172	85	87	42,508.8	7,721.0	34,096.6

Дээрх хүснэгтээс харахад: Аймгийн хэмжээнд 2014-2015 он, 2016 оны 01-р улирлын байдлаар 16-24 аж ахуй нэгж, байгууллага 172 хөгжлийн бэрхшээлтэй

буюу одой иргэнийг ажилд авч ажиллуулахаас 85 иргэнийг ажиллуулсан байна. Дээрх байгууллагууд хөдөлмөрийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрт 42.508.8 мянган төгрөгийг ХЭДС-д төвлөрүүлэхээс 7,721.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, 34.787.8 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн буюу уг төлбөрийн биелэлт 18 хувьтай байна.

Энэ нь Хөдөлмөрийн хэлтэс болон холбогдох ажил хариуцсан мэргэжилтэн нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүйн төлбөрийг төлөөгүй ААНБ-уудад хяналт шалгалт хийж, төлбөрийн акт тавих эрхгүй байгаагаас шалтгаалсан байна. Тухайлбал: Хууль хүчний байгууллагууд ХБИ ажиллуулах боломжгүй, төсвийн байгууллагуудын төсөвт уг төлбөрийг тусгаж, батлаагүй зэрэг шалтгаанаар ХБИ ажиллуулаагүйн төлбөрийг төлөхөөс зайлхийдэг байна.

Иймд Хөдөлмөрийн хэлтэс нь аймгийн хэмжээний байгууллагуудын нэгдсэн судалгаа мэдээллийн сантай болохоос гадна ХБИ ажиллуулах боломжгүй байгууллагуудаар уг төлбөрийг төлүүлэх, мөн ААНБ-уудын төлбөрийг төсөвт нь тусгуулан батлуулдаг байх, ХБИ ажиллуулаагүйн төлбөр төлөөгүй ААНБ-д холбогдох арга хэмжээ тооцдог эрх, үүргийг аймгийн хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтэнд олгох зэрэг асуудлуудыг бодлогоор зохицуулах тухай саналыг холбогдох дээд шатны байгууллага буюу Хөдөлмөрийн яаманд тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллах тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

ХЭДС-ийн хөрөнгийн зарцуулалт, олгосон зээлийн ашиглалт үр нөлөөтэй байна уу?

Бүлэг 2

ХЭДС-ийн хөрөнгийг зоруулалтын дагуу зарцуулаагүйгээс 26,417.7 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, олгосон зээлийн эргэн төлөлтийг дутуу төлсөн байна.

2.1. ХЭДС-аас олгох зээлийг хөтөлбөрийн зорилгыг хангаагүй иргэнд олгосон байна.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн 2.2.1-т "Малчин өрхийг малжуулах арга хэмжээнд хөдөлмөрийн чадвартай, 35 хүртэлх насны 2-оос доошгүй гишүүнтэй, бог малд шилжүүлснээр 150 хүртэлх толгой малтай малчин өрхийг хамруулах байтал 36 настай малчин С.Отгонтөгсийг хамруулж 4,000.0 мянган төгрөгийн мал худалдан авч өгсөн нь хөтөлбөрийн зорилгыг хангаагүй байна.

Иймд ХЭДС-аас олгож буй зээлийг хэрэгжүүлж буй хөтөлбөрийн зорилгыг хангасан иргэдэд олгож байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.


2.2. ХЭДС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөрийн санхүүжилтээс нийт 26,417.7 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, уг сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

2014 онд төсвийн санхүүжилтээр 410,000.0 мянга, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрт 2,764.8 мянга, өмнөх оны авлага 8,936.9 мянган төгрөг, нийт 421,701.7 мянган төгрөгийн санхүүгийн эх үүсвэртэй ажиллаж, гүйцэтгэлээр нийт 415,018.6 мянган төгрөгийг зарцуулж, орлого болон

санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл 6,683.1 мянган төгрөгийг ХЭДТөв санд төвлөрүүлсэн байна.

2015 онд төсвийн санхүүжилт 540,000.0 мянга, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрт 3,228.6 мянга, төслийн санхүүжилт 1,215.0 мянга, зээлийн эргэн төлөлт 262,016.5 мянга, нийт 806,460.1 мянган төгрөгийн эх үүсвэртэй ажиллаж, гүйцэтгэлээр нийт 483,938.4 мянган төгрөгийг зарцуулж, зээлийн эх үүсвэр 250,000.0 мянган төгрөгийг ХЭДТсанд, 72,521.7 мянган төгрөгийг Сангийн яаманд тус тус төвлөрүүлж ажилласан байна.

2014-2015 онуудын ХЭДС-н орлогын бүтцийг диаграмаар харуулбал:



Диаграмаар харахад 2014 оны нийт орлогын 97.2 хувийг санхүүжилт, 0.7 хувийг ХБИ ажиллуулаагүйн төлбөр, 2.1 хувийг өмнөх оны авлага эзэлж байгаа бол 2015 онд 67.0 хувийг санхүүжилт, 0.4 хувийг ХБИ ажиллуулаагүйн төлбөр, 32.4 хувийг зээлийн эргэн төлөлт, 0.2 хувийг төслийн санхүүжилт тус тус эзэлж байна.

2016 онд төсвийн санхүүжилт 70,800.0 мянга, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрт 1,728.0 мянга, зээлийн эргэн төлөлт 4,579.5 мянга, нийт 77,107.5 мянган төгрөгийн эх үүсвэртэй ажиллаж, гүйцэтгэлээр нийт 17,927.0 мянган төгрөгийг зарцуулж, зээлийн эргэн төлөлт 2,790.0 мянга, ХБИ ажиллуулаагүй төлбөр 345.6 мянга нийт 3,135.6 мянган төгрөгийг ХЭДТсанд төвлөрүүлж, 56,044.9 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.

Тус аудитаар ХЭДС-ийн үйл ажиллагаанд дараахь зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

1. “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 2014 онд 60,000.0 мянга, 2015 онд 55,855.0 мянга нийт 115,855.0 мянган төгрөгөөр мал худалдаж авахдаа ТБОНӨХБАҮХАТХ хуулийн дагуу нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулалгүйгээр зар тарааж, харьцуулалт хийх аргаар мал худалдаж авсан байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д Харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг, Засгийн газрын 2013 оны 68 тогтоолын хавсралтыг тус тус зөрчсөн байна.

Иймд ХЭДС-ийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ хуулийн дагуу зохион байгуулж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2. Хөдөлмөрийн сайдын 2015.03.13-ний өдрийн А/28 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар хавсралт ХХЭНХБИДХ-ийг хэрэгжүүлэх удирдамжийн 5 дугаар зүйлийн 5.3-д "Арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийг иргэдийн цалин, урамшуулал, хоолны зардалд зарцуулахгүй, өөрөөр хэлбэл хүнсний ногоо тариалахтай холбоотой үр бордоо, бага оврын багаж, тоног төхөөрөмжөөр иргэдийг хангах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа болон бусад холбогдох үйл ажиллагаанд зарцуулна" гэснийг зөрчиж 2014 онд Хүлэмж 4,840.0 мянга, ус нөөцлөх сав 1,500.0 мянга, 2015 онд услалтын систем 5,419.0 мянга, 40 тоннын чингэлэг 2,700.0 мянган төгрөгөөр тус тус худалдан авч нийт 14,459.0 мянган төгрөгийн хөрөнгийн хөрөнгө бэлтгэсэн,

Мөн дараахь зардлуудаас хөрөнгө бэлтгэсэн байна. Үүнд:

2014 онд

- Төсөл хөтөлбөр боловсруулахад зөвөлгөө өгөх зардлаас асар майхан 2,550.0 мянга,
- ХЭДС-ийн зөвлөлийн үйл ажиллагааны зардлаас фото аппарат 489.0 мянга, камер 439.7 мянга,
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвөлгөө өгөх мэдээллээр хангах үйлчилгээний зардлаас зөөврийн компьютер 1,859.0 мянга, камер 1,244.9 мянга,
- Хөдөлмөр эрхлэлт, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан, сүлжээ ажиллуулах зардлаас сангийн санхүүгийн программ 770.0 мянга, камерын спички 196.1 мянга,
- Сурталчилгаа нийтийг хамарсан өдөрлөгийг зохион байгуулах зардлаас камерын хөл 150.0 мянган төгрөгөөр тус тус худалдан авч нийт 7,548.7 мянган төгрөгийн хөрөнгийг зориулалт бусаар бэлтгэсэн байна.

2015 онд

- Борлуулалтын болон ажлын байрны дэмжлэг үзүүлэх зардлаас цахилгаан үүсгэвэр 580.0 мянга, ширээ сандал 1,440.0 мянга,
- Программ техник хангамжийн шинэчлэлийн зардлаас байгууллагын вэб сайт 990.0 мянга, архивын программ 300.0 мянга,
- Сурталчилгаа олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах зардлаас мэдээллийн урсдаг самбар 1,100.0 мянга нийт 4,410.0 мянган төгрөгийн хөрөнгө тус тус бэлтгэсэн байна.

Эдгээр нь ХЭДТХ-ийн 23 дүгээр зүйлийн 23.3-д Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно" гэснийг зөрчиж байна.

Иймд ХЭДС-ийн хөрөнгөөр Хөдөлмөрийн хэлтэст хөрөнгө бэлтгэсэн 300.0 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төлбөрийн акт тогтоож, ХЭДС-ийн

хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж буй зөрчил дутагдлуудад албан шаардлага, болон холбогдох зөвлөмжүүдийг өгөхөөр шийдвэрлэв.

3. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийг эзэмшсэн мэргэжлээр нь бизнес, аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжих, суралцагчдад хичээлээс хөндийрөхгүй, ажил, хөдөлмөр хийх туршлагажих, орлого олоход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор 8 бүлэг тус бүр 10,000.0 мянга, нийт 80,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 2015.12.15-нд олгосон байна.

Гэтэл төслийн үйл ажиллагаа нь одоог хүртэл тогтворжоогүй, бүлгийн гишүүд бүрэн бус /өөр газарт ажилд орсон, цэргийн албанд татагдсан, ар гэрийн гачигдал/, хөтөлбөрийн хүрээнд олгосон санхүүгийн дэмжлэгээр шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авсан авсан боловч уг тоног төхөөрөмжийг ашиглаж, үйл ажиллагаагаа явуулаагүй, худалдан авсан хөрөнгө нь бүлгийн удирдагч багш нарын эзэмшилд байгаа зэрэг нь тус хөтөлбөрийн зорилгыг хангахгүй байна: Тухайлбал:

1. “Сайн хийц төсөл” үйл ажиллагаа нь гагнуур хийх. Удирдагч багш, бүлгийн ахлагчтайгаа нийт 5 гишүүнтэй. Үүнээс 3 гишүүн нь байхгүй байгаа бөгөөд үйл ажиллагаа явуулах байраа засварлаж байна,
2. “Авто машины засвар угаалга төсөл” удирдагч багш, бүлгийн ахлагчтайгаа нийт 5 гишүүнээс 1 гишүүн байна. Үйл ажиллагаа явуулж байна,
3. “Бат бэх блок төсөл” удирдагч багш, бүлгийн ахлагчтай нийт 5 гишүүнээс 1 гишүүн байна. Үйл ажиллагаа явуулж, 1000 ширхэг болк хийсэн боловч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь чанарын шаардлага хангаагүйгээс борлуулах боломжгүй,
4. “Цэцэгчний хүслэн төсөл” удирдагч багш, бүлгийн ахлагчтайгаа нийт 5 гишүүнээс 3 гишүүн байна. Үйл ажиллагаа явуулж, цэцэг болон модны үрсэлгээ хийсэн байна.
5. “Автомашинны оношлогоо засвар үйлчилгээний төсөл” удирдагч багшаас өөр хүнгүй, худалдаж авсан тоног төхөөрөмж нь гэмтэлтэй тул ашиглалтын шаардлага хангаагүйгээс үйл ажиллагаа явуулаагүй,
6. “Цахилгаан тоног төхөөрөмж засвар төсөл” удирдагч багш, бүлгийн ахлагчтайгаа нийт 5 гишүүнээс 3 гишүүн байхгүй, тоног төхөөрөмжөө худалдан авч үйл ажиллагаа явуулж байгаа боловч ажлын байр нь халаалтгүй тул байнгын үйл ажиллагаа явуулаагүй,
7. “Арвин шим-Хандлан тэжээл бэлтгэх нөөцлөх төсөл” удирдагч багш, бүлгийн ахлагчтайгаа нийт 5 гишүүнтэй, улирлын чанартай тул, гишүүд амарсан. үйл ажиллагаа явуулдаг, тэжээл хийсэн гэх боловч 2 шуудай овъёс, 1 боодол өвсний нөөцтэй байна.
8. “Авто засвар үйлчилгээ төсөл” удирдагч багш, бүлгийн ахлагчтайгаа нийт 5 гишүүнээс 3 гишүүн байхгүй. Тоног төхөөрөмжөө худалдан авч үйл ажиллагаа явуулж байна.

Иймд тус сангийн санхүүгийн дэмжлэгээр авсан хөрөнгүүдийг бүрэн ашиглаж, бүлгийн гишүүдийг шинэчлэн, бүлгүүдийн үйл ажиллагааг нь тогтмолжуулж, төслийн үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар тордорхой арга хэмжээ авч ажиллах тухай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.3 ХЭДС-ийн хөрөнгийн хөрөнгөөр бэлтгэгдсэн 14,149.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

ХЭДСангаас хэрэгжүүлж буй хөтөлбөр, төслийн хүрээнд бэлтгэсэн 14,149.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаж, тайлагнаагүй байна. Үүнд: 2014 онд 4,840.0 мянган төгрөгийн Хүлэмж, 1,500.0 мянган төгрөгийн ус нөөцлөх сав, 2015 онд 5,419.0 мянган төгрөгийн услалтын систем, 300.0 мянган төгрөгийн Архивын программ, 990.0 мянган төгрөгийн байгууллагын вэб сайт, 1,100.0 мянган төгрөгийн мэдээллийн урсдаг самбар тус тус байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана” гэснийг зөрчсөн байна.

Иймд дээрх хөрөнгүүдийг холбогдох данс бүртгэлд бүртгэж, тайлагнах тухай албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

ХЭДС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, олон нийтэд ХЭДС-ийн орлогын бүрдүүлэлт, хуваарилалт зохих журмын дагуу хийгдэж байна

Бүлэг 3

ХЭДС-ийн хөрөнгийн зарцуулалтыг олон нийтэд ил тод мэдээлж байгаа боловч, хэрэгжилтэнд нь тавих хяналт хангалтгүй байна.

3.1. ХЭДС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.

2014 оноос ХЭДС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг олгохдоо “Бүртгэл хяналтын карт”-ыг хөтөлж, материалын бүрдлийг дотоод аудит хариуцсан мэргэжилтэн хяналт хийсний дараа байгууллагын удирдлагаар баталгаажуулан, олгож хэвшсэн байна.

ХЭҮЗ-ийн 2012.01.31-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор ХЭСЗ-ийг тус аймагт 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан ба уг зөвлөл нь ХЭДС-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж, эрх, үүргийнхээ хүрээнд санал, дүгнэлт, зөвлөмж, шийдвэр гаргаж, тус хэлтсийн Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт, шалгалт хийж зөвлөмж өгч ажилладаг хэдий ч тус сангийн хөрөнгийн зарцуулалт, хөтөлбөр, төслийн хэрэгжилт хангалтгүй байна.

Энэ нь ХЭДС-ийн салбар зөвлөл болон холбогдох ажилтнуудын ажлын үр дүн хангалтгүй, тус сангаас хэрэгжүүлж буй төсөл, дэмжлэг, олгож буй зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, үр дүнг сайжруулах талаар тодорхой ажил зохион байгуулж ажиллаагүйтэй холбоотой байгаа бөгөөд эдгээр зөрчлүүд нь ХЭДС-ийн үйл ажиллагааны үр дүнг бууруулж байна.

Иймд ХЭСЗ-ийн үйл ажиллагааг сайжруулах, ХЭДС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийг үр ашгийг нэмэгдүүлэх, хяналт, шинжилгээ, дотоод хяналтыг үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.2. ХЭДС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар олон нийтэд ил тод мэдээлж байна.

ХЭДС-ийн хөрөнгийн зарцуулалтыг байгууллагын санхүүгийн ил тодын самбар, байгууллагын болон аймгийн вэб сайт, Шилэн дансны нэгдсэн сайт, Аймгийн Холбооны газрын кабелийн телевиз, байгууллагын мэдээллийн урсдаг самбар зэрэг мэдээллийн бүхий л хэрэгслээр мэдээлэхээс гадна багийн хурал өдөрлөг, иргэдтэй хийж буй уулзалтуудаар иргэдэд мэдээлэл өгч, үйл ажиллагааны тайланг товхимол ном болгон нийтэд тараах зэргээр иргэдэд ил тод мэдээлэх ажлыг хангалттай зохион байгуулж ажилласан байна.

Мөн 2014 онд Аймгийн ЗДТГ, Мерси Кор ОУБ хамтран явуулсан “Төрийн байгууллагын үйл ажиллагааны иргэдэд хүртээмжтэй, ил тод байдал” санал асуулгаар “Хамгийн ил тод” байгууллагаар шалгарч өргөмжлөл, цомоор шагнагдсан байна.

3.3. ХЭДС-ийн үйл ажиллагаанд хийсэн хөндлөнгийн хяналт шалгалтын байгууллагаас өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.

ХЭДС-ийн 2014-2015 оны санхүүгийн тайлангийн аудитыг аймгийн Аудитын газар хийж, мөн 2013-2014 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Мэргэжлийн хяналтын газраас хяналт шалгалт хийсэн байна. Дээрх онуудын Санхүүгийн тайлангийн аудитаар болон Мэргэжлийн хяналтын байгууллагын шалгалтаар дараах зөрчил дутагдал илэрснийг засаж, залруулан ажилласан байна. Үүнд:

1. 2014 оны санхүүгийн тайлангийн аудитаар; Нийт 259,095.0 мянган төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг аудитын явцад залруулж, НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулах зөвлөмж өгсний дагуу НББББ-ийг боловсруулан байгууллагын даргын тушаалаар батлан, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаандаа 2015.12.20-ний өдрөөс эхлэн мөрдөж ажилласан байна.
2. 2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар ХБИ-ийг ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг төлөвлөгөөг 4,771.4 мянган төгрөгөөр дутуу биелүүлсэн тул орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллах зөвлөмж өгсөн байна. Уг зөвлөмжийг хэрэгжилтийн хугацаа болоогүй байна.
3. Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас ХЭДС-ийн 2013-2014 онуудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэн ба шалгалтаар нийт 25,409.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 11,578.8 мянган төгрөгийн зөрчлийг залруулан, 8,830.7 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн акт тогтоосон ба уг актыг хүлээн зөвшөөрөөгүй боловч 4,631.7 мянган төгрөгийн актыг нь барагдуулсан байна. Мөн 5,000.0 мянган төгрөгийн албан шаардлага өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1. ХЭДС-ийн орлогын төлөвлөгөөг жил бүр 4,773.4-7,235.2 мянган төгрөгөөр буюу 13.6-72.4 хувиар тасалсан байна.
2. ХЭДСангаас эргэн төлөгдөх нөхцөлтэй олгож буй зээлийг зээлийн барьцаа хөрөнгөгүйгээр олгосон, Эргэн төлөх хугацаандаа зээлээ төлөөгүй иргэдийн зээлд хүү алданги, торгууль тооцох зэрэг хариуцлагын ямар нэгэн заалтыг тусгаагүйгээс 33 иргэн 11,243.1 мянган төгрөгийн зээлийг дутуу төлсөн байна,
3. Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой иргэнийг авч ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг бодитой төлөвлөж, баталуулж ажиллаагүй, мөн уг төлбөр төлөх ААНБ-ын мэдээллийн санг байгуулж, төлбөрийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүйгээс орлогын төлөвлөгөөг тасалсан байна,
4. Хөдөлмөр эрхлэлтийн дэд санд орон нутгийн төсвийн орлогын 0.3 хувиас доошгүй хөрөнгийг төвлөрүүлэх хуулийн заалт хэрэгжээгүй байна,
5. ХЭДС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулалгүй, хөрөнгө бэлтгэсэн байна,
6. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, малжуулах хөтөлбөрийг зорилгын дагуу хэрэгжүүлээгүй байна,
7. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, малжуулах хөтөлбөрийг хүрээнд мал худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулаагүй байна,
8. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийг эзэмшсэн мэргэжлээр нь бизнес, аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжих, суралцагчдад хичээлээс хөндийрөхгүй, ажил, хөдөлмөр хийх туршлагажих, орлого олоход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор 8 бүлэг тус бүр 10,000.0 мянга нийт 80.000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгоод 5 сар болж байхад үйл ажиллагаа нь тогтворжоогүй, бүлгийн гишүүд байхгүй, гарааны хөрөнгө бэлтгэснээс өөр ажил хийгээгүй байгаа нь тус хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнгүй байгааг харуулж байна,
9. ХЭДС-ийн хөрөнгийн хөрөнгөөр бэлтгэгдсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна,
10. Дээрх зөрчил дутагдлаас харахад ХЭДС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, дэмжлэгүүд үр ашиггүй байгаа ба тус сангийн хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ зохион байгуулж ажиллаагүй байна,
11. ХЭДС-ийн зөвлөл болон тус байгууллагын дотоод хяналтын ажлын үр дүн хангалтгүй, үр нөлөө хангалтгүй байна,
12. Уг аудитаар нийт 249,794.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 300.0 мянган төгрөгөнд акт тогтоож, 94,149.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, мөн алдаа зөрчлийг арилгах, дахин давтан гаргахгүй байх чиглэлээр 155,345.4 мянган төгрөгөнд зөвлөмж өглөө
13. ХЭДС-ийн хөрөнгийн зарцуулалтыг олон нийтэд ил тод мэдээлэлт хангалттай байгаа боловч хэрэгжилтэнд тавих хяналт хангалтгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн даргын түр орлон гүйцэтгэгч Д.Баянжаргалд

1. ХЭДС-ийн батлагдсан орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллах,
2. Эргэн төлөгдөж нөхцөлтэй олгогдсон зээлийн гэрээнд зээлээ хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хүү, алданги тооцох зэргээр хариуцлагын талаар тодорхой заалт оруулах,
3. Тус сангийн эргэн төлөглөх нөхцөлтөйгээр олгож буй зээлийг барьцаа хөрөнгөтөйгээр олгож байх,
4. ХЭДС-аас хэрэгжүүлж буй хөтөлбөр, төслийн хөрөнгөөр зориулалт бусаар хөрөнгө бэлтгэхгүй байх
5. Аймгийн ХБИ ажиллуулах, төлбөр төлөх байгууллагын нэгдсэн судалгаа, мэдээллийн сантай болж төлбөрийн орлогыг бодитой төлөвлөн батлуулж, хэрэгжилтийн нь хангаж ажиллах,
6. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, малжуулах хөтөлбөрийг хүрээнд мал худалдан авахдаа бэлтгэн нийлүүлэгчийг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу нээлттэй тендер шалгаруулалтаар сонгох,
7. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийг эзэмшсэн мэргэжлээр нь бизнес, аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжих, суралцагчдад хичээлээс хөндийрөхгүй, ажил, хөдөлмөр хийх туршлагажих, орлого олоход нь санхүүгийн дэмжлэг олгосон 8 бүлгийн үйл ажиллагааг тогтмолжуулах, гишүүдийг нь нөхөж бүрдүүлэх, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, хянах замаар хөтөлбөрийг зорилгын дагуу хэрэгжүүлэх,
8. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.9.1-д “энэ хуулийн 22.1.2-т заасан хөрөнгийг аймгийн төсөвт жил бүр тусгуулах талаар санал боловсруулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах,
9. Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулж, сангийн хөрөнгийн зарцуулалт, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллах.
10. ХЭДС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, дэмжлэгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, үр ашгийг сайруулахад чиглэсэн арга хэмжээг авч ажиллах,
11. Аудитаар тависан төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжилтийг хангаж ажиллах.

ХЭДСангийн мэргэжилтэн, үйл ажиллагааны нягтлан бодогч нарт

1. ХЭДС-ийн орлогыг төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөж, батлуулах, батлагдсан орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллах,
2. ХЭДС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгийг холбогдох данс, бүртгэлд бүрэн бүртгэж, тайлагнаж байх,

3. ХЭДС-аас эргэн төлөгдөх нөхцөлтөйгөөр олгосон зээлийг гэрээнд заасан хуваарийн дагуу бүрэн төлүүлэх,
4. ХЭДС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, дэмжлэгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, үр ашгийг сайруулахад анхаарч ажиллах
5. Нийцлийн аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, давтан гаргахгүй байх, тависан төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжилтийг хангаж ажиллах.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ХЭЛТЭС

42011 Чойр, Сүмбар сум, Говьсүмбэр аймаг,
Утас/Факс: (976) 7054-3518

2016-05-30 № 156
танай 2016-05-21-ны № 150 -т

АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР ШИЧИНХОРЛОО ТАНАА

Ц.Батбаяр
Саналын танилцуулга
- нд
2016/5

Тайлбар хүргүүлэх тухай

Танай байгууллагаас ирүүлсэн Нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцан дараах санал, тайлбарыг хүргүүлж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сүлжээ нь хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл цуглуулах, боловсруулах, хадгалах, хамгаалах, түүнээс мэдээлэл түгээх, цахим хуудас, түүнд суурилсан программ болон техник хангамж, мэдээллийн бусад арга хэрэгслээс бүрдэнэ гэж заасан байдаг.

Үүний дагуу бүртгэл мэдээллийн сүлжээ ажиллуулах зардлаас 2015 онд 990,000 төгрөгийг гарган байгууллагын цахим хуудас / вэб сайт/-ыг "Том амжилт" ХХК-тай гэрээ байгуулан хийлгэсэн.

ХЭДСангаас орон нутагт хэрэгжиж буй хөтөлбөр төслийн хэрэгжилт, хамрагдсан иргэдийн мэдээлэл гэх мэт ХЭДСангийн үр дүнг харуулсан мэдээллүүдийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд хүргэдэг.

Манай байгууллагын цахим хуудас нь үндсэн 6 цэснээс бүрдсэн байдаг.

ХЭДСангаас хэрэгжиж буй хөтөлбөр төслийн талаарх мэдээлэл байдаг. Тус хэлтэс 2015 онд Хөдөлмөрийн яамны харьяа аймаг дүүргийн хэлтсүүдээс ажлын үр дүн, үзүүлэлтээрээ 2 дугаар байранд орсон нь вэб сайт болон бусад боломжит бүх хэлбэрээр ХЭДСангийн үйл ажиллагааны талаарх бүхий л мэдээллийг ил тод байршуулан мэдээлж байсны үр дүн гэж үзэж байна.

Иймд төлбөр тогтоох актаар зориулалт бусаар зарцуулсан гэх 1,290,0 мянган төгрөгний 990,0 мянган төгрөгийг хасуулах саналтай байна.

Жич: Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолын дагуу 2015 онд Архивын улсын үзлэг болохтой холбогдуулан архивын программ суулган, хэлтсийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг явуулах зайлшгүй шаардлагатай байсан тул Хэлтсийн үйл ажиллагааны зардалд төсөв байхгүй байсан учраас ХЭДСангаас 300,000 төгрөгийг гарган Архивын программ хийлгэн архивын бүх мэдээллүүдийг оруулж, одоо архивын баримт бичгүүдийг цахим хэлбэрт оруулах ажил хэвийн явагдаж байна.

Нийцлийн аудитаар ирүүлсэн зөвлөмжийн дагуу ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

ДАРГА



Д БАЯНЖАРГАЛ

D:\Бичиг хэрг\A4 тоот 1.docx

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ХИЙСЭН ТАЙЛБАР

Танай байгууллагаас ирүүлсэн албан бичиг, санал, тайлбартай танилцаад дараахь тайлбарыг хийж байна. Үүнд:

1. ХЭДС-аас зориулалт бусаар зарцуулж архивын программ худалдан авсан 300.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг орон нутгийн орлогын 220000954 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Вэб сайтын үнэ 990,0 мянган төгрөгийг төлбөрийн актнаас чөлөөлж, зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв..